

**УВС АЙМГИЙН САГИЛ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ**

Огноо: 2025.01.23

Увс аймгийн Сагил сумын цэцэрлэгийн хүүхдийн хоолонд шаардлагатай бүтээгдэхүүнийг нийлүүлэх  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын  
нэр:  
Гэрээний нэр:

Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүн  
нийлүүлэх

Төслийн дугаар:

**УВАССХЦ/20250202001**

Харьцуулалт/  
гэрээний дугаар:

**ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ,  
ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ**

**Увс аймгийн Сагил сум 2025 оны 01 сар 23**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Сагил сумын хүүхдийн цэцэрлэг нь эрх бүхий тендерт оролцогчдоос цэцэрлэгийн “Хүүхдийн хоол”-нд шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна. Тендерийн төсөвт өртөг 58,362,000 (тавин найман сая гурван зуун жаран хоёр мянган) төгрөг. Тендер дараах багцаас бүрдэнэ.

- Үүнд: 1 багц. Мах махан бүтээгдэхүүн
- 2 багц. Сүү, сүүн бүтээгдэхүүн
- 3 багц. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ
- 4 багц. Гурил, гурилан бүтээгдэхүүн
- 5 багц. Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн

Тендерт оролцох хүсэлтэй этгээд үнийн саналыг **2025 оны 01 сарын 31-ний** өдрийн 13<sup>00</sup> цагаас өмнө [tender.gov.mn](http://tender.gov.mn) рүү илгээнэ үү.

Үнийн саналыг нээлтэнд оролцох хүсэлтэй **тендерт оролцогчдыг байлцуулан 2025 оны 01 сарын 31- ний өдрийн 13<sup>30</sup>** минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээлэлийг доорх хаягаар авч болно.  
**Tender.gov.mn** хаягаар орж авна.

Оролцох хүсэлттэй компани иргэдийг урьж байна.

**Увс аймгийн Сагил сумын хүүхдийн цэцэрлэгийн**

**үнэлгээний хороо**

**Утас: 86149997; 99452550**

**А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

<b>1. Тендерийн цар хүрээ</b>	<p>1.1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (цаашид ТШӨХ гэж товчлох)-д тодорхойлсон захиалагч (цаашид “захиалагч” гэх) нь энэ тендерийн баримт бичгийн ТШӨХ болон техникийн тодорхойлолтод заасан бараа, материал болон тоног төхөөрөмж (цаашид “бараа” гэх) худалдан авах тухай гэрээ байгуулахаар энэхүү тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт нь ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд нэг багцтай байна.</p> <p>1.3. Олон багцтай тендер шалгаруулалтын тендерийн баримт бичгийг багц тус бүрээр үнэлж зарахыг хориглоно.</p> <p>1.4. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолтод нийцсэн барааг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан хугацаанд, газарт хүргэх үүрэгтэй.</p>
<b>2. Санхүүжилтийн эх үүсвэр</b>	<p>2.1. Захиалагч дээр дурдсан барааг ТШӨХ-д тодорхойлсон эх үүсвэрээр санхүүжүүлнэ.</p>
<b>3. Залилан мэхлэх болон авлигын үйлдэл</b>	<p>3.1. Төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцож гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.</p> <p>3.2. Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч нь Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэх үүрэгтэй.</p>
<b>4. Эрх бүхий тендерт оролцогч</b>	<p>4.1. Тендерийн урилга нь сонирхсон этгээд бүрт нээлттэй. Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч болон түүний түншлэлийн гишүүн бүр нь аль ч улсын харъяалалтай байж болно.</p> <p>4.2. Дараах тохиолдолд тендерт оролцогч (түншлэлийн гишүүн бүрт нэгэн адил хамаарна)-ийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:</p> <p>4.2.1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;</p> <p>4.2.2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;</p> <p>4.2.3. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтэц, зохион байгуулалт болон санхүүгийн хувьд захиалагчаас хараат байдлаар үйл ажиллагаа явуулдаг бол;</p> <p>4.2.4. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;</p> <p>4.2.5. Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) нь бараа, ажил, үйлчилгээний зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;</p> <p>4.2.6. Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;</p> <p>4.2.7. Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;</p> <p>4.2.8. Энэхүү тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;</p>

- 4.2.9. Энэхүү тендерийн баримт бичгийн ТООЗ-ны 14 дүгээр зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендер ирүүлсэн бол;(Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендер ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3. Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
5. **Эрх бүхий бараа**
- 5.1. Гэрээгээр нийлүүлэх бараа нь аль ч улсын гарал үүсэлтэй байж болно. Захиалагч төлбөрийг зөвхөн ТООЗ-ны 1.1-д дурдсан барааг хүлээн авснаар төлнө.
- 5.2. Энэхүү зааварчилгааны 5.1-д дурдсан барааны гарал үүсэл гэдэгт тухайн барааг олборлосон, ургуулсан, бойжуулсан, эсхүл хийж бүтээсэн улс орон буюу газар нутгийг хэлнэ. Хийж бүтээсэн гэж үйлдвэрлэсэн, боловсруулсан, эсхүл эд ангиудын дийлэнхийг угсарч, энэ эд ангиудын үндсэн шинж чанар, зориулалт, эсхүл ашиглалтын хэлбэрээс илт өөр арилжааны шинэ бараа гаргаж ирэхийг хэлнэ.

## 6.

### Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

#### 7. Тендерийн баримт бичгийн агуулга

- 7.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан 3 хэсэг баримт бичиг болон ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ. Үүнд:
- Тендерт оролцогчид өгөх зааварчилгаа  
Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт  
Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт  
Тендер шалгаруулалтын маягт
- Тендерийн маягт
  - Үнийн хуваарь
  - Үйлдвэрлэгч/гэрээт борлуулагчийн зөвшөөрлийн маягт

Бараа нийлүүлэлтэд тавигдах шаардлага, техникийн тодорхойлолт

- 7.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 7.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөн ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болж болно.

#### 8.Тендерийн баримт бичгийг тодруулах

- 8.1. Тендерт оролцохыг сонирхогч нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо ("утсан холбоо"-нд зөвхөн телекс болон факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ. Захиалагч тендер хүлээн авах хариу нь хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хүрнэ.

Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.

- 8.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан шаардлага байгаа үзвэл энэхүү ТООЗ-ны 9дүгээр зүйл, 24.2 дэгл хэсэгт заасан журмыг баримтлан.

#### 9. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах

- 9.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.2. Ийнхүү оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.
- 9.3. Тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийн улмаас тендер зайлшгүй өөрчлөгдөх ба уг өөрчлөлтийг бэлтгэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчид олгох шаардлагатай гэж үзвэл захиалагч 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.

## В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- |                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
|------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>10. Тендер шалгаруулалт оролцоо зардал</b>  | 10.1. Тендерт оролцогч тендер бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>11. Тендерийн хэл</b>                       | 11.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотойгоор захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидлууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн баримт бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвөл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална.<br>11.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТООЗ-ны 11.1-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг тендерийг хянан үзэх, үнэлэхэд харгалзана.                                                                                                                                                            |
| <b>12. Тендерийн иж бүрдэл</b>                 | 12.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) ТООЗ-ны 13, 15 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болон үнийн хуваарь;<br>(б) захиалагч шаардсан бол ТООЗ-ны 21 дүгээр зүйлд заасны дагуу ирүүлэх тендерийн баталгаа;<br>(в) тендерт оролцогчийг төлөөлж ТООЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл;<br>(г) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 17 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;<br>(д) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТООЗ-ны 18 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;<br>(е) нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээ нь тендерийн баримт бичигт нийцэж буйг баталгаажуулсан ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нотлох баримт;<br>(ё) ТШӨХ-д шаардсан ТООЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх бусад материал.                 |
| <b>13. Тендерийн маягт болон үнийн хуваарь</b> | 13.1. Тендерт оролцогч нь Бүлэг 4-т заасан тендерийн маягтыг бөглөж ирүүлнэ. Энэхүү маягтыг бөглөхдөө түүний агуулгыг өөрчлөлгүйгээр түүнд шаардсан бүх мэдээллийг тусгана.<br>13.2. Тендерт оролцогч нь нийлүүлэх бараа болон түүнийг дагалдах үйлчилгээний үнийн хуваарийг бэлтгэн ирүүлнэ. Үнийн хуваарийг 4 дүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын маягтаас тохирох маягтыг ашиглан бэлтгэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
| <b>14. Хувилбарт тендер</b>                    | 14.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>15. Тендерийн үнэ болон үнийн хөнгөлөлт</b> | 15.1. Тендерийн маягт болон үнийн хуваарь дахь тендерт оролцогчийн санал болгож буй үнэ болон, үнийн хөнгөлөлт нь дор тодорхойлсон шаардлагад нийцсэн байна.<br>15.2. Үнийн хуваарьт бүх багц болон нэр төрлийг үнэ тус бүрээр нь тусад нь жагсааж ирүүлнэ.<br>15.3. Тендерийн маягтад тусгасан үнэ нь аливаа үнийн хөнгөлөлтийг тооцоогүй тухайн тендерийн нийт үнэ байна.<br>15.4. Тендерт оролцогч нь аливаа нөхцөлт бус үнийн хөнгөлөлт болон түүнийг хэрэглэх аргачлалыг тендер ирүүлэх маягтад тусад нь тусгасан байна.<br>15.5. Олон улсын худалдааны EXW, CIP болон ижил төстэй бусад нөхцөлийг хэрэглэхдээ ТШӨХ-д дурдсан, Олон улсын худалдааны танхимаас эрхлэн гаргасан <b>Incoterms-ийн</b> хамгийн сүүлийн хувилбарыг удирдлага болгоно.<br>15.6. Нийлүүлэх барааны үнийг тендерийн маягт (Бүлэг 4)-д заасан үнийн хуваарь бүрээр гаргаж ирүүлнэ. Ингэхдээ тендерт оролцогч нь гэрээний дагуу нийлүүлэх барааны нэгж үнэ, тухайн нэр төрлийн нийт үнэ, нийт дүн, барааны |

гарал үүслийн улсын нэрийг бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрөл бүрээр холбогдох үнийн хуваарьт тусгаж ирүүлнэ. Үнийн задаргааны агуулга нь захиалагчаас тендерийг харьцуулж үнэлэх зорилгоор шаардагдана. Энэ нь санал болгосон аливаа нөхцөлөөр гэрээ байгуулах захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.

15.7. Гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар хураамжийг тендер хүлээж авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг үндэслэн тендерийн үнэд багтаасан байна.

15.8. Барааг багцалсан эсэх талаарх мэдээллийг ТООЗ-ны 1.2 дахь заалт болон түүнд харгалзах ТШӨХ-ийн заалтаас үзнэ үү. Хэрэв багцалсан бол тендер оролцогч нэг, эсхүл түүнээс олон багцад тендер ирүүлэх эрхтэй. Аливаа багцыг хувааж дэд багц болгон тендер ирүүлэхийг хориглоно.

15.9. Үнийн хуваарьт дараах зүйлсийг тусад нь бичиж харуулна. Үүнд:

(а) Монгол Улсад үйлдвэрлэгдсэн барааны хувьд:

1. барааны EXW үнэ (үйлдвэрийн, агуулахын, эсхүл лангууны үнийн аль тохирохыг). Энэ үнэд барааг үйлдвэрлэх, угсрахад ашигласан үйлдвэрийн, эсхүл лангууны үнээр үнэлэгдсэн эд анги, түүхий эд, үйлдвэрлэлийн бусад өртөг багтана;

2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор дотоодын бүтээгдэхүүнд ногдуулдаг нэмэгдсэн өртгийн болон бусад адилтгах албан татвар;

3. барааг ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(б) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд импортоор орж ирэх барааны хувьд:

1. ТШӨХ-д захиалагчийн нэрлэсэн хилийн боомт хүртэлх СИФ/CIF/ үнэ, эсхүл захиалагчийн нутаг дэвсгэр дэхь нэрлэсэн байрлал хүртэлх СИП /CIP/ үнэ;

2. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирэх бараанд ногдох гаалийн, нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

3. барааг орох боомтоос буюу нэрлэсэн байрлалаас ТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардагдах хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(в) Монгол Улсын гадна үйлдвэрлэгдсэн бөгөөд өмнө нь импортоор орж ирсэн барааны хувьд:

1. барааны үнэ буюу импортоор анх орж ирсэн тухайн барааны үнэ дээр үнийн нэмэгдэл/эсхүл хөнгөлөлт/, дотоодод гарсан аливаа нэмэлт өртөг, тухайн бараанд төлсөн эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татваруудыг тооцсон үнэ;

2. импортлогдсон бараанд урьд төлсөн(нотлох баримтыг хамт ирүүлэх шаардлагатай), эсхүл төлөгдөх гаалийн болон импортын бусад татварууд;

3. тухайн барааг олж авахад зарцуулсан өртөг буюу энэ заалтын 1 болон 2 –ын ялгавар;

4. гэрээ байгуулах эрх олгогдсоноор импортоор орж ирсэн бараанд ногдох нэмэгдсэн өртгийн болон бусад албан татвар;

5. бараагТШӨХ-д заасан эцсийн цэгт хүргэхэд шаардлагатай хуурай газрын тээвэр, даатгал болон дотоодод гарах бусад зардал.

(г) Барааны Техникийн тодорхойлолт болон холбогдох үйлчилгээний талаарх шаардлагад тодорхойлсон Дагалдах үйлчилгээний хувьд:

Гэрээ байгуулах эрх олгогдсоноор Дагалдах үйлчилгээнд ногдох Худалдан авагч орны гаалийн, худалдааны болон бусад адилтгах албан татварыг тооцож

(1) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн дотоодын валютаар илэрхийлэгдэх зардлын өртөг;

(2) Дагалдах үйлчилгээг бүрдүүлж буй зүйл тус бүрийн гадаадын валютаар илэрхийлэгдэх зардлын өртгийг тус тус харуулна.

15.10. ТШӨХ-д гэрээний үнийг тохируулах нөхцөлтэй байхаар тусгайлан зааснаас

бусад тохиолдолд тендер оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна. Тендерийн үнийг гэрээний хэрэгжилтийн явцад тохируулж өөрчлөхөөр санал болгосон аливаа тендерийг ТООЗ-ны 31 дүгээр зүйлд заасны дагуу үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж, уг тендерээс татгалзана. Гэвч ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан нөхцөлд тогтмол үнэ санал болгосон тендерээс татгалзахгүй бөгөөд түүний үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэг (0)-тэй тэнцүү байна гэж үзнэ.

- 15.11. ТШӨХ-д үнэ тохируулахаар заасан бол үнэ тохируулах нөхцөл, аргачлалыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.
- 15.12. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 16. Тендерийн валют**
- 16.1. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дах хэсэгт заасны дагуу тендерийн үндсэн валют нь төгрөг байна.
- 17. Тендерт оролцогч эрх бүхий эсэхийг нотлох баримт**
- 17.1. Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (a) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар,
  - (б) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл;
  - (в) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн бараа нийлүүлэх тусгай зөвшөөрөл.
- 18. Тендерт оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлох баримт**
- 18.1. Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ. Үүнд:
- (a) хэрэв ТШӨХ-д шаардсан бол тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг Монгол Улсад нийлүүлэх эрх олгосон тухай үйлдвэрлэгчийн зөвшөөрлийг 4 дүгээр бүлгийн маягтаас тохирох маягтыг ашиглан ирүүлнэ;
  - (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан тоо бүхий жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;
  - (в) гэрээг хэрэгжүүлэх удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
  - (г) тухайн тендерт оролцогчийн туршлагыг харуулах сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний талаарх мэдээлэл;
  - (д) хэрэв ТШӨХ-д шаардсан бол Монгол Улсын нутаг дэвсгэрт бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй тендерт оролцогч гэрээний дагуу хийгдэх засвар үйлчилгээ, техникийн тодорхойлолтод заасан сэлбэг хэрэгслийг нийлүүлэх үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн этгээд өөрөө гүйцэтгэх, эсхүл уг тендерт оролцогчийн Монгол Улсад байгуулсан, эсхүл байгуулагдах төлөөлөгч биелүүлэх тухай баримт;
  - (e) захиалагч тендерт оролцогчийн харилцагч банкнаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн мэдэгдэл;
  - (ё) одоогийн ба сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
  - (ж) гэрээний үнийн 10-аас дээш хувьтай тэнцэх дүнтэй ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүний чадварын талаарх мэдээлэл.
- 18.2. Тендерт оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан барааг нийлүүлэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
- (a) сүүлийн 5 жилийн аль нэг жилд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан дүнгээс багагүй байх;
  - (б) сүүлийн [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг бараа нийлүүлэх үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага;
  - (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах санал;
  - (г) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа төлбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
  - (д) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

19. **Нийлүүлэх бараа нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт**
- 19.1. Тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримтыг тусгайлан бэлтгэж тендерт ирүүлнэ. Нотлох баримт нь нийтлэл, зураг, өгөгдлийн хэлбэрээр байж болох ба дараах мэдээллийг агуулна. Үүнд:
- (а) барааны техникийн болон үйл ажиллагааны шинж чанарын дэлгэрэнгүй тодорхойлолт;
  - (б) барааг [ТШӨХ-д заасан тоо] жилийн хугацаанд тасралтгүй, горимын дагуу ажиллуулахад шаардагдах сэлбэг хэрэгсэл, тусгай багаж болон бусад зүйлсийн жагсаалт. Тус жагсаалтад тэдгээрийг аль улсаас, хаанаас нийлүүлэх боломжтойг, мөн нэгж үнэ зэрэг холбогдох мэдээллийг дурдана;
  - (в) нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцэхийг зүйл, заалт бүрээр нотлон харуулсан тайлбар, эсхүл тус тодорхойлолтын аль нэг зүйл, заалтыг орхигдуулсан, зөрсөн боловч захиалагчийн тогтоосон техникийн тодорхойлолтын шаардлагыг үндсэнд нь хангаж байгааг нотолсон мэдэгдэл;
  - (г) захиалагчийн техникийн тодорхойлолтод дурдсан чанар, материал болон тоног төхөөрөмжийн стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаар нь тухайн бараанд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлох бөгөөд түүгээр хязгаарлагдахгүйг тендерт оролцогч анхаарч 19.1.(в)-ийн дагуу тайлбар ирүүлнэ.
- Тендерт өөр стандарт, барааны тэмдэг, каталогийн дугаарыг орлуулан хэрэглэж болох бөгөөд орлуулах зүйл нь техникийн тодорхойлолтод заасантай дүйцэхүйц, эсхүл түүнээс илүү шаардлага хангасан гэдгийг тендерт оролцогч захиалагчид нотлон харуулна.
20. **Тендер хүчинтэй байх хугацаа**
- 20.1. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангаагүй тендер гэж үзэж татгалзана.
21. **Тендер ирүүлэх хувь, тендер гарын үсэг зурах**
- 21.1. Тендерт оролцогч 12 дугаар зүйлд заасан тендерийн бүрдэл баримт бичгийн эх хувиудыг бэлтгэн хавтаслаж, түүнд **"ЭХ ХУВЬ"** гэсэн тодорхой бичиглэл хийнэ.
- 21.2. Тендерийг эх хувийг хэвлэж (компьютер, бичгийн машин гэх мэт), эсхүл арилдаггүй бэхээр бичиж, тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулна. Тендерт оролцогчийн боловсруулсан тендерийн агуулга, үнэтэй холбоотой бүх хуудсанд төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурна. Хэвлэмэл танилцуулга, тайлан болон бусад байгууллагын гаргасан албан ёсны мэдээлэл зэрэг баримт бичиг үүнд хамаарахгүй.
- 21.3. Тендер ирүүлэхээс өмнө захиалагчийн гаргасан зааварчилгаатай нийцүүлэх, эсхүл тендерт оролцогч өөрийн алдааг зайлшгүй шаардлагаар засахаас бусад тохиолдолд тендерт ямар нэг засвар, нэмэлт бичилт хийхгүй ба засвар, нэмэлт бичилт хийсэн тохиолдолд зөвхөн дээрх эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар тэдгээр засвар өөрчлөлтийг хүчинтэйд тооцно.

## Г. ТЕНДЕР ИРҮҮЛЭХ

22. **Тендерийг битүүмжлэх, бичиглэл хийх**
- 22.1. Тендерт оролцогч өөрийн тендерийг шуудангаар, эсхүл өөрийн бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ.
- 22.2. Тендерийн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэнэ. Тендерээ дугтуйлж, битүүмжлэхдээ ТООЗ-ны 22.3, 22.4 –т заасныг баримтална.
- 22.3. Дугтуй нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- (а) тендерт оролцогчийн нэр, хаяг, холбогдох утасны дугаартай байх;
  - (б) **ТШӨХ-д заасан** хаягаар ТООЗ-ны 1.1-т заасан захиалагчийн нэр дээр хаяглах;
  - (в) тендер шалгаруулалтыг таних, ялгах тэмдэг болгож ТООЗ-ны 1.1 болон **ТШӨХ-д** тодорхойлсон тендер шалгаруулалтын нэр/дугаарыг тодорхой бичсэн байх;
  - (г) ТООЗ-ны 27.1-т заасан хугацаанаас өмнө **"НЭЭЖ ҮЛ БОЛНО"** гэж тэмдэглэгдсэн байх
- 22.4. Хэрэв дугтуйг 22.3-т заасан шаардлагын дагуу битүүмжилж, бичиглэл хийгээгүй нөхцөлд уг тендер буруу хаягаар хүргэгдсэн, эсхүл тендер нээхээс өмнө битүүмжлэл задарсан тохиолдолд захиалагч хариуцлага хүлээхгүй.
- 22.5. ТООЗ-ны 22.1-т зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн аливаа тендерийг захиалагч хүлээж авахгүй бөгөөд түүнийг хаягаар нь буцаана.
23. **Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 23.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 23.2. Захиалагч ТООЗ-ны 9 дүгээр зүйлийн дагуу тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсны улмаас тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгасан

тохиолдолд захиалагч болон тендерт оролцогчийн эрх, үүрэг сунгасан хугацааны туршид хэвээр хадгалагдана.

- 24. Хугацаа хоцорсон тендер**
- 24.1. Захиалагч ТООЗ-ны 23 дүгээр зүйлд заасан тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн аливаа тендерийг “хугацаа хоцорсон” гэж зарлан түүнээс татгалзаж, нээлгүйгээр буцаана.
- 25. Тендерт оролцогч нэг этгээд нэг тендер ирүүлэх**
- 25.1. Аливаа этгээд дангаараа, эсхүл хамтран ажиллах гэрээний үндсэн дээр түншлэл болж тендер шалгаруулалтад оролцохдоо зөвхөн нэг тендер ирүүлнэ. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүд нэгээс дээш тендер ирүүлсэн, бол түүний ирүүлсэн бүх тендерээс татгалзана.
- 26. Тендерт нэмэлт өөрчлөлт хийх, тендерийг буцааж авах**
- 26.1. Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагчид бичгээр мэдэгдэл өгсний үндсэн дээр өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, солих, эсхүл түүнийг буцааж авах эрхтэй.
- 26.2. Тендерт нэмэлт өөрчлөлт оруулах, тендерийг солих эсвэл буцааж авах мэдэгдлийг 21 дугаар зүйлийн дагуу бэлтгэн, битүүмжилж, бичиглэл хийхийн хамт дугуй дээр “НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ”, “ТЕНДЕРИЙГ СОЛИХ ТУХАЙ”, эсхүл “ТЕНДЕРИЙГ БУЦААЖ АВАХ ТУХАЙ” гэсэн бичиглэл хийнэ. Тендерийг буцааж авах мэдэгдлийг утсан холбоогоор ирүүлж болох ба энэ мэдэгдэл хүчин төгөлдөр болохыг батламжилж гарын үсэг, тамга бүхий эх хувийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө заавал ирүүлнэ.
- 26.3. Тендер хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш аливаа тендерт ямар нэг нэмэлт өөрчлөлт хийх, солих, эсвэл буцааж авахыг зөвшөөрөхгүй.
- 26.4. ТООЗ-ны 27.2-т заасны дагуу тендерээ буцааж авах тухай хүсэлт ирүүлсэн оролцогчийн үндсэн тендерийг нээлгүйгээр буцаан олгоно.

---

#### **Д. ТЕНДЕРИЙГ НЭЭХ, ҮНЭЛЭХ**

---

- 27. Тендерийг нээх**
- 27.1. Захиалагч тендерийн нээлтийг ТШӨХ-д заасан огноо, цагт, заасан хаяг бүхий газарт зохион байгуулна. Тендер нээх үед тендерт оролцогч, эсхүл түүний төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд байлцах эрхтэй ба байлцсан бол тендерийн нээлтийн тэмдэглэлд гарын үсгээ зурна.
- 27.2. Тендерийг нээх үед тендерт оролцогчийн нэр, тендерийн үнэ, санал болгосон бол үнийн хөнгөлөлт, оролцогч өөрийн тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан бол уг нэмэлт өөрчлөлтийг болон захиалагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг зарлаж, тэмдэглэл үйлдэнэ. Тендер нээх үед зарлагдаагүй тендерийн үнэ, үнийн хөнгөлөлт болон хувилбарт тендерийг үнэлгээнд харгалзахгүй.
- 27.3. Захиалагч тендерийн нээлтийн тэмдэглэлийг хөтлөх бөгөөд уг тэмдэглэл нь дараах мэдээллийг заавал агуулсан байна. Үүнд:
- (a) тендерт оролцогчийн нэр болон тухайн тендерт оролцогч тендерээ буцааж авсан, эсхүл тендерт нэмэлт өөрчлөлт оруулсан буюу тендерээ сольсон эсэх;
  - (б) тендерийн үнэ болон санал болгосон үнийн хөнгөлөлт .Нэгээс дээш багцтай тендер шалгаруулалтын үед эдгээр мэдээллийг багц тус бүрээр гаргах;
  - (в) захиалагч тендерийн баталгаа шаардсан бол түүнийг ирүүлсэн эсэх
- 28. Нууцлах**
- 28.1. Тендерийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг гэрээ байгуулах эрх олгох хүртэлх хугацаанд тендерт оролцогчид болон тухайн тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй аливаа этгээдэд задруулахыг хориглоно.
- 28.2. Захиалагч тендерийг хянан үзэх, үнэлэх, харьцуулах явцад, эсхүл гэрээ байгуулах эрх олгох шийдвэрт тендерт оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн тендерээс татгалзах үндэслэл болно.
- 28.3. Тендерийн нээлт хийснээс хойш гэрээ байгуулах эрх олгох хүртэл хугацаанд захиалагч болон тендерт оролцогчид хоорондоо зөвхөн бичгээр харилцана.

- 29. Тендерийг тодруулах**
- 29.1. Тендерийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулах явцад тендерийг үнэлэхэд зайлшгүй шаардлагатай бол захиалагч тендерт оролцогчоос түүний тендерийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно. Тендерийг тодруулахтай холбоотой аливаа харилцааг бичгээр явуулна. Гэхдээ 30 дүгээр зүйлийн дагуу тендерийг хянан үзсэний үндсэн дээр захиалагчийн илрүүлсэн арифметик алдааг залруулахаас бусад тохиолдолд тендерийн үнэ болон агуулгад ямар нэг өөрчлөлт хийхийг хүсэх, санал болгохыг зөвшөөрөхгүй.
- 30. Тендерийг хянан үзэх, шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох**
- 30.1. Аливаа тендерийг нарийвчлан үнэлэхээс өмнө уг тендер нь дараахь шаардлагыг хангаж буй эсэхийг хянан үзнэ. Үүнд:
- (а) ТООЗ-ны 4 дүгээр зүйлд заасан эрх бүхий тендерт оролцогч байх шаардлагыг хангасан эсэх;
- (б) тендерт зохих ёсоор гарын үсэг зурж, баталгаажуулсан эсэх;
- (в) тендерийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагад нийцсэн эсэх;
- (г) тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварын доод шаардлагыг хангасан эсэх.
- 30.2. ТООЗ-ны 30.1 дэх заалтын (а) - (г)-д заасан заалт тус бүрийг хангаж буй тохиолдолд шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ.
- 30.3. Шаардлагад нийцсэн тендер гэж тендерийн баримт бичгийн бүх нөхцөл болзол, тендерт оролцогчийн үйлдвэрлэлийн хүчин чадал, санал болгосон бараа нь ТООЗ-ны 19 дүгээр зүйлд заасан нөхцөл болон техникийн тодорхойлолтыг материаллаг зөрүүгүйгээр хангаж буй тендерийг хэлнэ. Дор дурдсан зүйлсийг материаллаг зөрүү гэж үзнэ. Үүнд:
- (а) тендерт санал болгож буй бараа нь техникийн тодорхойлолт болон гэрээний нөхцөлд тодорхойлсон барааны хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол;
- (б) гэрээнд заасан захиалагчийн эрх, тендерт оролцогчийн үүрэгт тендерийн баримт бичигтэй үл нийцэх зарчмын хязгаарлалт оруулсан бол;
- (в) зөрүүг хүлээн зөвшөөрч засварлах буюу залруулах нь шаардлагад нийцсэн бусад тендерийн өрсөлдөөнд шударга бусаар нөлөөлөх бол.
- 30.4. Захиалагч шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон тендерээс татгалзана. Харин тендерт оролцогч түүнд засвар хийж шаардлагад нийцсэн болгож болохгүй.
- 31. Алдааг залруулах**
- 31.1. Захиалагч шаардлагад нийцсэн гэж тодорхойлогдсон тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна. Үүнд:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэж тоондүнг засварлах;
- (б) нэр төрлийн нийт үнийн нийлбэр нь тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл нэр төрлийн нийт үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулах;
- (в) нэр төрлийн нийт үнэ нь түүний нэгж үнийг тоо ширхэгээр үржүүлэхэд гарсан үнээс зөрвөл нэр төрлийн нэгж үнийг үндэслэн түүний нийт үнийг залруулна. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 31.2. Захиалагч, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн үнэнд залруулга хийхээр байвал энэ талаар тухайн тендерт оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг бичгээр баталгаажуулж авна.
- 32. Дотоодын давуу эрх**
- 32.1. Захиалагч ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерүүдийг үнэлж харьцуулахдаа Монгол Улсын гарал үүсэлтэй бараа санал болгосон тендерт бусад гарал үүсэлтэй бараа санал болгосон тендертэй харьцуулахад давуу эрхийн зөрүү олгохгүй.
- 33. Тендерийг үнэлэх, харьцуулах**
- 33.1. Захиалагч зөвхөн 30 дүгээр зүйлийн дагуу шаардлагад нийцсэн гэж тогтоогдсон тендерийг үнэлж, харьцуулна.
- 33.2. Шаардлагад нийцсэн тендерүүдийг 33.2-т заасны дагуу үнэлгээ хийж тендер тус бүрийн харьцуулах үнийг тогтооно. Хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна.
- 33.3. ТШӨХ-д заасны дагуу хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд “хамгийн сайн” үнэлэгдсэн үндсэн тендерийг шалгаруулна.

- 33.4. Барааг ТООЗ-ны 1.2 дахь хэсэгт хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг багц тус бүрт хийх бөгөөд харин гэрээ байгуулах эрх олгохдоо нэг багц, хэд хэдэн багц, эсхүл бүх багцын аль үр ашигтай хувилбарыг сонгож болно.
- 33.5. Олон багцтай тендер шалгаруулалтад “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийг шалгаруулж, тэдгээрт гэрээ байгуулах эрх олгох хамгийн үр ашигтай хувилбарыг сонгохдоо захиалагч 3 дугаар бүлэг буюу үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт дэхь олон багцтай тендерийг үнэлэх тухай тусгайлан заасан аргачлалыг мөрдөнө.

**34. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах**

- 34.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 34.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 18.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 29 дугаар зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн тодорхойлно. Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 34.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад, шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

**35. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах захиалагчийн эрх**

- 35.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

**Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ**

**36. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**

- 36.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.3-т заасны дагуу “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 36.2. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй оол гэрээ байгуулахаас татгалзсан гэж тооцож, тендерээс татгалзана.

**37. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл**

- 37.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгох шийдвэрээ гаргаж тендер нь шалгарсан оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ.
- 37.2. Шалгарсан тухай мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлт үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 37.3. Гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг мэдээлсний дараа шалгараагүй тендерт оролцогч өөрийн тендерийн үнэлгээний талаар тайлбар авах хүсэлтийг бичгээр гаргаж болно. Хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.

**38. Захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед тоо өөрчлөх**

- 38.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төсөл арга хэмжээний үед захиалагч гэрээ байгуулах эрх олгох үед үнэ, бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн техникийн тодорхойлолтод дурдсан барааны тоо **ХЭМЖЭЭГ** ширхэгийг ТШӨХ-д заасан хувиар өөрчлөх эрхтэй.

**39. Гэрээнд гарын үсэг зурах**

- 39.1. Захиалагч гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 39.2. Шалгарсан тендерт оролцогч гэрээний маягыг хүлээн авснаас хойш ажлын 5-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хугацаанд багтаан түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.

## ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТӨӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвөл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	<b>А. Ерөнхий зүйл</b>
ТӨӨЗ 1.1	Захиалагч нь: <b>Увс аймаг Сагил сумын хүүхдийн цэцэрлэг</b>
ТӨӨЗ 1.1	тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: Цэцэрлэгийн хүүхдийн хоолонд шаардлагатай БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ <b>УВАССХЦ/20250202001</b>
ТӨӨЗ 1.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 1. багц : Сүү сүүн бүтээгдэхүүн 2. багц : Хүнсний ногоо 3. багц : Гурил гурилан бүтээгдэхүүн 4. багц : Мах махан бүтээгдэхүүн 5. багц : Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн
ТӨӨЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсөв</b>
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
ТӨӨЗ 8.1	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <b>Увс аймгийн Сагил сумын ЕБС-ийн Санхүү албаны өрөө, Нябо Ч. Баттогтох</b>
ТӨӨЗ 8.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын <b>5 хоногоос багагүй байна.</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>
ТӨӨЗ 12.1 (ё)	Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд: 1. Байгууллагын ажилтны танилцуулга, удирдах ажилтан, хариуцсан менежерийн мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбар 2. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт авч ирүүлэх, /эх хувиар/ 3. Харъяа татварын хэлтэсийн тодорхойлолт ирүүлнэ /тодорхойлолт 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх, хуулбар хувь ирүүлэх бол хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлж болно/. 4. Нийлүүлэх барааны баталгаат хугацааны мэдэгдэл гаргаж ирүүлэх. 5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./ 6. Тендерт оролцогч уг тендерийн багцад шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан барааг нийлүүлж гэрээний үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 7. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 8. Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шинжилгээний дүгнэлтийн хуулбар 9. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх, 10. Аймгийн болон сумын мал эмнэлэгийн гарал үүслийн гэрчилгээний хуулбар ирүүлэх 11. Бүтээгдэхүүний жагсаалт, нэгж үнийн саналыг дөрвөн улиралаар гаргаж ирүүлэх 12. Ажилчдын эрүүл мэндийн байдлыг тодорхойлсон мэргэжлийн байгууллагын үзлэг, шинжилгээний бичиг ирүүлэх. <b>Дээрх материалуудыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</b>
ТӨӨЗ 14.1	Хувилбарт тендер ирүүлэхийг <b>“зөвшөөрөхгүй”</b> .
ТӨӨЗ 15.9	Бараа хүргэгдэх газар: <b>Увс Сагил сумын хүүхдийн цэцэрлэг</b>
ТӨӨЗ 15.10	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад <b>“ тогтмол байна”</b>
ТӨӨЗ 16.1	Тендерийн валют: <b>Төгрөг байна.</b>

ТӨЭЗ 18.1 (а)	Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл: “шаардлагатай” Санал болгож буй барааны гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.
ТӨЭЗ 18.1 (б)	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2023 оны тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан,
ТӨЭЗ 18.4	Дотоодын давуу эрхийн зөрүү: <b>“тооцохгүй”</b>
ТӨЭЗ 19.1.(б)	Барааг тасралтгүй горимын дагуу ашиглах, эсхүл ажиллуулахаар тооцоолж буй хугацааны үе (энэ хугацаанд шаардагдах сэлбэг хэрэгслийг тооцоолох зорилготой): <b>1 хувь</b>
ТӨЭЗ 20.1	Тендер нээснээс хойш <b>30</b> хоногийн туршид хүчинтэй байна.
ТӨЭЗ 22.1	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>0 хувь</b>
<b>Г. Тендер ирүүлэх</b>	
ТӨЭЗ 23.3 (б)	Тендер хүлээн авах захиалагчийн хаяг: Сагил сумын хүүхдийн цэцэрлэг эрхлэгч Ж.Отгонжаргал Тендер хүлээн авах этгээд: <b>Сагил сумын хүүхдийн цэцэрлэг</b> Байгууллагын хаяг: <b>Увс аймгийн Сагил сум 5-р баг</b> Аймаг, хот: <b>Увс</b> Шуудангийн дугаар: <b>Үгүй</b> Улс: <b>“Монгол Улс” Увс аймаг</b>
ТӨЭЗ 23.3 (в)	Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:  Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: <b>2025 оны 01 дугаар сарын 31-ний өдөр</b> <b>Цаг: 13 цаг 00 минут хүртэл тендерийг хүлээн авна.</b>
<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>	
ТӨЭЗ 28.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: <b>Увс аймаг Сагил сумын Наран цэцэрлэг</b> Давхар болон өрөөний дугаар: <b>Багш хөгжлийн өрөө</b> Аймаг, хот: <b>Увс аймаг.</b> Шуудангийн дугаар: <b>Үгүй</b> Улс: <b>“Монгол Улс”</b> Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: <b>2025 оны 01 дугаар сарын 31-ний өдөр</b> <b>Цаг: 13 цаг 30 минутанд тендерийг нээнэ</b>
<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>	
ТӨЭЗ 40.1	Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b> Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>Үгүй</b>
ТӨЭЗ 42.1	Гүйцэтгэлийн баталгаа:

### БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Барааны тодорхойлолт:** хүүхдийн хоол хүнсэнд нийлүүлэгдэх бүтээгдэхүүн нь дараах 5 багцтай байна. багц тус бүрийн бүтээгдэхүүнийг нэгжийн үнийн дүнгээр сонгоно.

1. багц : Сүү сүүн бүтээгдэхүүн
2. багц : Хүнсний ногоо
3. багц : Гурил гурилан бүтээгдэхүүн
4. багц : Мах махан бүтээгдэхүүн
5. багц : Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн

**1-р багцад тавигдах шаардлага:** гурилан бүтээгдэхүүнд Боов боорцог, талх ,хэрчсэн гурил байх ба норм нормативаар өгөгдсөн илчлэг бүхий хэмжээгээр хүүхэд бүрт 100-120 гр байна. 1 өдөрт хамрагдах хүүхдийн тоо 100-125

Бүтээгдэхүүнийг бэлтгэх явцад түүхий эдэд сахар орлуулагч зэрэг хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болох зүйлсийг оруулахгүй.

Стандартын шаардлага хангасан сайн чанарын гурил, элсэн чихэр зөгийн бал зэрэг түүхий эдээр хийгдсэн байна. Мөн хүүдэд өгч болох, стандарт орц нормд тохирсон шинэ төрлийн боорцог, байж болно. түүнийгээ холбогдох стандартын байгууллагаар шинжилгээ лабораторид хамруулж дүгнэлт гаргасан бичгийг авч ирэх.

**2-р багцад тавигдах шаардлага: Хүнсний ногоо** нь эх орны хөрсөнд ургаж тарьсан хүнсний өргөн хэрэглээний ногоо байвал зохих ба холбогдох хяналтын байгууллагад хамрагдсан шинжилгээний бичиг, дүгнэлтын бичигтэй байна. мөн хадгалагдах зорь савны байршил зургийн бас хавсаргана.

**3-р багцад тавигдах шаардлага: Сүү, сүүн бүтээгдэхүүнд** цэвэр сүү, аарц, тараг, хоормог зэрэг бүтээгдэхүүн байх ба чанарын шаардлагыг хангасан мэргэжлийн байгууллагын дүгнэлт бүхий бүтээгдэхүүнүүд байна.

**Сүүнд тавигдах шаардлага:**сүү нь шаардлагатай шинжилгээнд хамрагдсан стандартын дагуу байна.

**Ааруул аарцанд тавигдах шаардлага:** шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр монгол аргаар хийгдсэн боз биш аарц байна.

**Тарганд тавигдах шаардлага:** шаардлагатай шинжилгээнд хамрагдсан малын сүүгээр хийгдсэн хүүхдэд хэрэгтэй стандарт илчлэг нормыг хангасан байна.

**4-р багцад тавигдах шаардлага: Мах махан бүтээгдэхүүнд** хүүхдийн норм илчлэгт тохирсон биеийн өсөлтөт маш тохиромжтой 1-р зэргийн хонь, үхрийн мах байвал зохино.

**Хонины маханд тавигдах шаардлага:** малын гарал угшилын бичиг, малын эмчийн бичиг, шаарлагатай шинжилгээнд хамрагдсан байна.

**Үхрийн маханд тавигдах шаардлага:** малын гарал угшилын бичиг, малын эмчийн бичиг, шаарлагатай шинжилгээнд хамрагдсан байна. мөн тээвэрлэх машин хадгадах зорь савны байршил зургийн бас хавсаргана.

**5-р багцад тавигдах шаардлага: Бусад, хуурай хүнсний бүтээгдэхүүн** нь хүүхдийн хоолонд оролцох хэрэглээний сагсны төрлөөс сонгох ба тус бүтээгдэхүүний гаралын бичиг үйлдвэрлэсэн он сар өдөр, үйлдвэрлэсэн газар тодорхой байна. мөн чанарын баталгаатай байх ба хадгалах хугацаа, болон одоо хадгалаж байгаа склад нь стандартын дагуу байх шаардлагатай.

### БАРАА НИЙЛҮҮЛЭЛТ

1. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:** Бүтээгдэхүүнийг хүүхдийн тоогоор ажлын өдөр бүр хүлээн авах ба шаардлагатай тоогоор өглөө бүр захиална. Бүх нийтийн амралтын өдөр болон зайлшгүй шийдвэрээр цэцэрлэг амарсан хугацаанд захиалгыг хаана. Бүтээгдэхүүний тээвэрлэлтийн зардлыг нийлүүлэгч хариуцах ба өдөр бүр захиалсан хэмжээгээр нярав хүлээн авна.

2. **Тавигдах бусад шаардлага, хяналт:** Бүтээгдэхүүний орц норм болон тендерийн шаардлага, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн явцад захиалагчийн зүгээс хэсэгчилсэн болон бүрэн хяналт шалгалтыг хийж дүгнэлт хийж байна.

Бүтээгдэхүүн бүрийн хугацаа тодорхой, зориулалтын савалгаатай байна, үйлдвэрлэгчийн ажилтнуудын шинжилгээний бичиг хавсаргасан байна.

**Үйлдвэрлэлийн орчинд тавигдах шаардлага:** Үйлдвэрлэгч нь зориулалтын байр савтай байна. Тоног төхөөрөмж нь зориулалтын, ариун цэврийн шаардлагыг хангасан байна.

3. **Баглаа, боодол:** Барааг захиалагч хүлээн авах хүртэл баглаа боодол стандартын шаардлага, эрүүл ахуйг хангасан байна.

**Бараа хүргэх газар :** Увс аймаг Сагил сумын хүүхдийн цэцэрлэг

Нэр төрөл	Барааны нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгжийн үнэ	Бүгд	Тайлбар
Мах махан бүтээгдэхүүн	Хонины мах	2000	Кг	10000	20000000	1-р зэргийн хонины мах, эрүүл мэндийн шинжилгээний бичигтэй, Эрүүл ахуйн улсын байцаагчид үзүүлж, тамга тэмдэг даруулсан байх.Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Үхрийн мах	234	Кг	11000	2574000	1-р зэргийн үхрийн мах, эрүүл мэндийн шинжилгээний бичигтэй, Эрүүл ахуйн улсын байцаагчид үзүүлж тамга тэмдэг даруулсан байх.Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх
	Сүү	1500	Л	4000	6000000	Үхэр, ямааны хольцгүй 100%-н сүү шинжилгээний бичигтэй. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Тараг	80	Л	6000	480000	Малын цэвэр сүүгээр бүрсэн, удаагүй сагаж гашуураагүй байх. Тээвэрлэлт,

Сүү, сүүн бүтээгдэхүүн						хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Аарц	80	Кг	10000	800000	Хольцгүй 100% өтгөн, хөгцөрч эвдрээгүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Хайрцагтай сүү	30	ш	4500	135000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Йогурт	300	ш	1500	450000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Масло	50	Кг	13000	650000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
Төмс, хүнсний ногоо	Төмс	360	Кг	3000	1080000	Зөв хэлбэртэй, Монгол сортын эвдэрч муудаагүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Манжин	350	Кг	3000	1050000	Зөв хэлбэртэй, Монгол сортын эвдэрч муудаагүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Байцаа	360	Кг	3500	1260000	Зөв хэлбэртэй, Монгол сортын эвдэрч муудаагүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Лууван	350	Кг	3500	1225000	Зөв хэлбэртэй, Монгол сортын эвдэрч муудаагүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Сонгино	30	Кг	5000	150000	Зөв хэлбэртэй, Монгол сортын эвдэрч муудаагүй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Амтат чинжүү	30	Кг	10000	300000	Орос, эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх
	Хүрэн манжин	30	Кг	3000	90000	Эвдэрч муудаагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Брокколи	30	Кг	10000	300000	Эвдэрч муудаагүй, эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Далайн байцаа	50	Ш	4500	225000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Шөлний байцаа	10	ш	5000	50000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Чацарганы шүүс	50	Л	10000	500000	Монгол сортын цэвэр байгалийн гаралтай, үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Варень	180	Ш	6500	1170000	Үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх
	Крем	36	ш	6500	234000	Үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх.

						Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх	
	Үзэм	50	Кг	11000	550000	Үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх	
	Үхрийн нүд	40	Л	16000	640000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
Жимс, жимсгэнэ	Зөгийн бал	50	ш	4000	200000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Хатаасан алим	60	Кг	10000	600000	Орос сортын үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Хар чавга	20	Кг	15000	300000	Орос сортын үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Алим	80	Кг	10000	800000	Орос сортын үйлдвэрлэсэн болон эрх бүхий байгууллагын гарал үүслийн бичигтэй байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Молоко	30	ш	10000	300000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Мандарин	80	Кг	10000	800000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Тарвас	100	Кг	2000	200000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
	Үхрийн нүд	40	л	16000	640000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.	
		Гурил	800	Кг	2000	1600000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.

Гурил, гурилан бүтээгдэхүүн	Цагаан будаа	300	Кг	3500	1050000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Гоймон	75	Ш	4000	300000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Уурагжуулсан гоймон	385	Ш	1200	462000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Шпагетти	125	Кг	2500	312500	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Алтан тарианы гоймон	52	Кг	1600	83200	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Гурвалжин будаа	86	Кг	7000	602000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Хөөлт	79	Ш	500	39500	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Хөц	96	Кг	4000	384000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Каш	85	Кг	4000	340000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Шар будаа	95	Кг	4000	380000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Загасан талх	34	Ш	2500	85000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон

						хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Хар талх	30	Ш	2500	75000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Печень	100	Кг	10000	1000000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Цайны боорцог	65	Кг	4200	273000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Амтат боорцог	50	Кг	4200	210000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Еэвэн	203	Кг	4200	852600	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Кавришка	210	Кг	4200	882000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Аарцтай боорцог	60	Кг	4200	252000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Мөөхий	170	Кг	4200	714000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Саран боорцог	196	Кг	4200	823200	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Маахуур	40	Кг	4200	168000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт,

						хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Өндөгтэй печень	40	Кг	10000	400000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Чикопой	400	ш	600	240000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Талх	1000	ш	2500	2500000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
Бусад бүтээгдэхүүн	Давс	70	кг	1300	91000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Цай	15	Кг	16000	240000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Өндөг	250	Ш	500	125000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Элсэн сахар	70	Кг	4500	315000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Молоко	30	Ш	10000	300000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Шоколадны крем	36	Ш	6500	234000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Өөхөн тос	50	Кг	3000	150000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
	Ургамлын тос	30	Ш	10000	300000	Эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан хаяг

						шошго, үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаа нь тодорхой байх. Тээвэрлэлт, хадгалалтын горим алдагдаагүй байх.
--	--	--	--	--	--	--------------------------------------------------------------------------------------------------------------

4. Үйл ажиллагааны хуваарь

Гэрээнд заасан хугацаандаа, дотоод үйл ажиллагааг тасралтгүй хэвийн жигд хангах нөхцөлөөр хангагдсан 2025 оны 01 сарын 31 хүртэлх хугацаанд багтаж, тухайн үеийн цэсээр 7 хоног бүр нийлүүлнэ.